

## МОНГОЛ-ХЯТАДЫН СОЁЛЫН ХАРИЛЦААНЫ ШИНЭ ӨРНӨЛТ

Ван Дачи\*

4-р сард Улаанбаатар хүйтэн жавартай боловч, Хятад - Монголын найрсаг харилцаа гудамж талбайд дулаан уур амьсгал оруулав. Хоёр улсын Засгийн газар хоорондын соёл урлагийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн дагуу Хятадын соёлын өдрүүдийг 2002 оны 04-р сарын 07-13 ны өдрүүдэд Монгол улсад анх удаа зохион байгууллаа. Энэхүү соёлын өдрүүд нь Хятад Монголын хооронд дипломат харилцаа тогтносноос хойш хамгийн өргөн цар хүрээтэй соёл урлагийн арга хэмжээ болсон юм. Үүнд:

- Циркийн тоглолт
- Дуу бүжгийн чуулга
- Хятадын үндэсний хөгжмийн үзэсгэлэн
- “Үзэсгэлэнт Хятад орон” нэртэй зургийн үзэсгэлэн
- Уран сайхны кино зэрэг төрлүүд багтсан байлаа.

Хоёр улсын Засгийн газар тус өдөрлөгийг чухалчлан үзэж, БНХАУ-ын Соёлын яамны сайд Сунь Жяжэн тэргүүтэй төлөөлөгчид Монгол улсад айлчилж, тус өдөрлөгийн нээлтийн арга хэмжээнд оролцож энэ үеэр Монголын БСШУЯамны сайд А.Цанжидтай уулзаж хоёр орны соёлын харилцааны асуудлаар санал бодлоо солилцсон билээ. Уулзалтын үеэр Хятад Монгол улсын Засгийн газрын 2004-2006 оны соёл урлагийн салбарт хамтран ажиллах ажлын төлөвлөгөөнд гарын үсэг зурлаа. Монгол улсын Ерөнхий сайд Н.Энхбаяр төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан бөгөөд тус өдөрлөгийн нээлтийн ажиллагаа, Хятад улсын урлагийн мастеруудын тоглолтыг

үзэж сонирхжээ. Дээрхи өдөрлөг нь маш богино хугацаанд болсон хэдий ч Монголын 2 сая гаруй ард түмний сэтгэлд хоногшин үлджээ.

Энэ удаагийн соёлын өдөрлөг нь Монголын ард түмэнд өөрийн биеэр Хятадын соёл урлагийн гайхамшгийг үзэж сонирхох сайхан боломж олгосон юм. Ингэснээр Монголын ард түмэн Хятад улсыг илүү сайн мэдэж, хоёр улсын хооронд найрсаг харилцаа гүнзгийрэн хөгжихөд түлхэц болж, түүнчлэн ард түмний найрамдлыг улам бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр орууллаа. Мөн үеэр Хятад улсын Соёлын яамны сайд Сунь Жяжэн хэлэхдээ, “Соёл урлагийн харилцаа бол хүмүүсийн хоорондын харилцаа бөгөөд тэдний оюун санааг холбож нэгтгэдэг. Энэхүү харилцаа ба холбоос нь ойлголцол, найрамдал, хамтын ажиллагааг бий болгодог билээ” гэжээ.

Сүүлийн жилүүдэд Хятад Монголын найрсаг харилцаа тасралтгүй хөгжсөнөөр бие биедээ харилцан айлчлах соёл урлаг, боловсрол, биеийн тамир болон бусад салбарын төлөөлөгчдийн тоо жил ирэх тусам нэмэгдэж байна. Хятад улсад зохиогддог олон улсын шинж чанартай соёл урлагийн арга хэмжээнд Монголын урлаг соёлын зүтгэлтнүүд байнга оролцдог болсон. Мөн Хятад улсад суралцах оюутан залуус жил бүр өсөн нэмэгдэж, хоёр улсын их дээд сургуулиудын харилцаа улам бүр өргөжиж байна. Хятад улсаас уран сайхны хамтлаг болон жүжигчид Монголд айлчлан тоглолт хийж байна. Хятадын оюутнууд Монголын олон их дээд сургуулиудад суралцаж, мэдлэг

\*Ван Дачи. БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ-ны соёлын зөвлөх

боловсролоо дээшлүүлж байна. Үүгээр хоёр улсын хамтын ажиллагаанд томоохон дэвшил гарч байна.

Миний бие Монгол улсад 3 жил гаруй ажиллах хугацаанд хоёр улсын соёл урлаг болон боловсролын салбарын хүрээн дэх харилцаа өргөжиж, Монголын Ардын дуу бүжгийн чуулга, Бүх цэргийн дуу бүжгийн ансамбли болон өсвөр үеийн уран сайханчид жил бүр Хятад улсад зохиогддог олон улсын уран сайхны баярт оролцож байна. Тухайлбал, Бээжин дэх тавдугаар сарын уулзалт, Азийн урлагийн наадам, Олон улсын үндэстний баяр гэх мэт.

Монгол улсын Улсын цирк, Монголын нэрт дуучин, төгөлдөр хуурч, хийлчид, балетийн бүжигчид Хятад улсад очиж Хятадын Ү Цяо олон улсын циркийн баяр, Шанхайн Азийн дуу дуулаачдын уралдаан, Бээжинд зохиогддог олон улсын төгөлдөр хуурчдын уралдаан, олон улсын дуулаачдын их наадам, уралдаан болон Шанхайн олон улсын балетийн бүжигчдийн фестиваль зэрэг их наадамд амжилттай оролцсон юм. Мөн хоёр орны солилцооны дагуу дуурийн төв театр, Хятадын Ханжоу хотын дуу бүжгийн чуулга, Өвөр Монголын циркийн жүжигчид болон бусад муж хотын жүжигчид бас Монголд ирж тоглолт хийн олон улсын шинжтэй төрөл бүрийн урлаг соёлын арга хэмжээнд оролцож ирлээ. Түүнчлэн Өвөр Монголын Хөх хот, Монголын Улаанбаатар хот хамтран соёлын өдрүүдээ зохион байгуулав.

Монголын нэрт дуучин Ариунаа, Наран, Сэрчмаа нар бас Хятад улсад очиж хаврын баярын үдэшлэг, урлагийн баярт оролцсон. 2004 оны хаврын баярын үеэр Хятадын ЭСЯ, Өвөр Монголын телевиз хороо, Монголын үндэсний телевиз хамтран хаврын баярын телевизийн үдэшлэг зохион байгуулж хоёр орны жүжигчид хамтран тоглолт хийн хоёр орны телевизээр нэвтрүүлсэн нь үзэгчдийн талархлыг хүлээсэн юм.

Хоёр орны ард түмний харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж залуучууд хоорондын нөхөрлөлийг гүнзгийрүүлэх

зорилгоор Хятадад суралцагсдын Монголын холбоо, Хятадын ЭСЯ хамтран анх удаа “Дорнын уянга” хятад дуу дуулаачдын уралдаан зохион байгууллаа. Энэхүү үйл ажиллагаа нь залуучуудын талархлыг ихэд хүлээн бараг зуугаад хүн оролцсон бөгөөд оролцогчид Хятадаар дуулсан нь өөрсдийн урлагийн авъяас, тайзны ур чадвар өндөртэйгээ харуулсан бөгөөд тус үйл ажиллагаа нь амжилттай болж одоогоор 2 дахь уралдаан нь зохиогдохоор бэлтгэгдэж байна.

Боловсролын солилцоо улам бүр хөгжих хандлагатай байна. Хоёр орны боловсролын солилцоо нь хоёр орны харилцаа сэргэснээс хойш улам хурдацтай хөгжиж ирсэн. Хоёр орны их дээд сургуулиуд харилцаа холбоо тогтоож эхэлсэн бөгөөд МУИС Хятадын Бээжингийн Их Сургуультай холбоо тогтоосны дараа УБИС, Хүмүүнлэгийн Их Сургууль, МУБ Их Сургууль зэрэг улсын сургуулиуд түүнчлэн “Их засаг”, “Отгон тэнгэр” зэрэг хувийн сургуулиуд Хятадын Бээжингийн гадаад хэлний их сургууль, Гадаад харилцааны их сургууль, Ардын их сургууль, Даляний Гадаад хэлний дээд сургууль, Хэбэй их сургууль, Хэбэй ХААИС, Өвөр Монголын их сургууль, Өвөр Монголын Багшийн их сургууль, Зүүн хойд Хятадын Багшийн их сургууль зэрэг сургуулиудтай холбоо тогтоосон.

Хятад Монгол хоёр орны их сургуулиудын захирлууд харилцан айлчилж, сургалтын туршлага солилцон оюутнуудаа харилцан сургасан явдал нь сургууль хоорондын харилцан ойлголцлыг бэхжүүлж хоёр орны оюутнуудын нөхөрлөл, сургууль хоорондын харилцаа, хөгжилд үр дүнгээ өгсөн юм. Энэ оны 5-р сард Монгол улсын ерөнхийлөгч Н. Багабанди БНХАУ-д айлчилсан бөгөөд айлчлах хугацаандаа Хятадын Засгийн газар өөрийн зардлаар сургах оюутны тоог 40-өөр нэмэгдүүлснийг мэдэгдэж жилд 220 хүн сургахаар болсон нь 2 орны боловсролын харилцаа шинэ шатанд хүрснийг илтгэж байна. 2004 онд Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас

их дээд сургуулийн оюутнууд болон бага дунд сургуулийн сурагчдын хятад хэлний олимпиадыг улсын шинжтэй уралдаан болгож жил бүр зохион явуулахаар батламжилсан. Хятадын Боловсролын яам болон Гадаад дахь хятад хэлний сургалт эрхлэх албаны дэмжлэгтэйгээр Хятадын Шандуны их сургуульд Монголын хятад хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг хоёр жил дараалан нэг сарын хугацаатайгаар зохион явуулсан ба Монголын хятад хэлний 40 багш үүнд хамрагдан оролцсон. Мөн Хятадын Гадаад дахь хятад хэлний сургалт эрхлэх албанаас 2 профессорыг Улаанбаатарт томилон ирүүлж хятад хэлний багш нарын богино хугацааны мэргэжил дээшлүүлэх сургалт зохион явуулсан бөгөөд түүнд 40 орчим монгол багш оролцсон. Бид бас Монголын боловсролын их сургуульд (хуучнаар Монголын багшийн их сургууль) HSK Хятад хэлний түвшин тогтоох шалгалт авах төв байгуулсан бөгөөд өнгөрсөн жилийн Хятад Хэлний Түвшин Тогтоох Шалгалтанд 130 гаруй хүн оролцлоо.

Хоёр орны дээд хэмжээний харилцан аичлалыг дагаад бусад салбарын солилцоо, хамтын ажиллагаа тасралтгүй бэхжиж, Хятад Монгол хоёр орны сайн хөрш, харилцан итгэлцэл, түншлэлийн харилцаа улам бүр хөгжиж, хоёр орны ард түмний урт удаан жилийн түүхтэй уламжлалт нөхөрлөл улам бүр бэхжихийн хирээр соёл

боловсролын үйл ажиллагаа шинэ шатандаа орж байна. Хятад улс 1980-аад оны сүүлээс Хятадын засгийн газрын тэтгэлэгээр суралцагч Монгол оюутнуудыг хүлээн авч эхэлсэн ба сүүлийн жилүүдэд жил бүр 180 оюутан авч сургаж иржээ.

Хятад Монгол хоёр орны улс төрийн харилцааны тасралтгүй хөгжлийг дагаад эдийн засгийн харилцаа ч бас улам бүр өргөжиж, Хятадад очиж бизнес эрхэлж буй монгол иргэд болон Монголд ирж компани байгуулан ажиллаж буй хятад иргэд жил ирэх тутам өсөн нэмэгдэж, Хятад улсыг ойлгож мэдэх эрмэлзэлтэй хүмүүс олширохын хирээр харилцан ойлголцох болон харилцааны гол хэрэглүүр хэл сурах явдал чухал болов. Иймээс сүүлийн жилүүдэд Монгол улсад хятад хэлний сургалт явуулдаг сургууль хэдийнээ МУИС хэмээх нэг их сургуулиас халин арав гаруй их сургууль, арав гаруй бага дунд сургууль, хятад хэлний мэргэжлийн сургууль болтлоо өргөжин өсч хятад хэлний оюутнуудын тоо ч хэдэн арваас хэдэн мянга болтлоо өсч, хятад хэл сурах явдал өргөжиж байна. Хятад хэлний өсөн нэмэгдэж буй хэрэгцээг дагаад Хятадын ЭСЯ болон Монгол-Хятадын найрамдлын нийгэмлэг, МУИС, Монголын “Юй Цай” хятад хэлний дунд сургууль хамтран “Оюутны хятад хэлний олимпиад” болон бага дунд сургуулийн сурагчдын хятад хэлний олимпиадыг тус тус зохион явууллаа.